ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
**САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР**
Дархан сумын Засаг Даргын Тамгын Газрын байр
Өргөө баг, Дархан сум, Дархан-Уул аймаг, 45040
Утас: (+976) 7507-4222
Цахим шуудан: sankhuu_audit@darkhan.gov.mn
Цахим хуудас: sankhuu.audit.da.gov.mn

2026.07.09 № 97

танай _____-ны №_____ -т

ОРХОН СУМЫН ЗАСАГ ДАРГА
Б.ТҮМЭНЦОГТ ТАНАА

Орхон сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2026 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт хийсэн шалгалтын тэмдэглэлийг хүргүүлэв.

Хавсралт 13 хуудастай.

ДАРГА Л.ДАГИЙСҮРЭН

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТЭМДЭГЛЭЛ

2026 оны 07 сарын 09 өдөр Дугаар 23-06-26/08 Дархан

ОРХОН СУМЫН "ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН" -Д САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙСЭН ТУХАЙ

Нэг. Нийтлэг зүйл

1.1 Хяналт шалгалтын зорилго

Дархан-Уул аймгийн Засаг даргын баталсан Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын 2026 онд хийх хяналт шалгалтын төлөвлөгөө, 2026 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 23-06-26-01/06 дугаар удирдамжийн дагуу Орхон сумын "Орон нутгийн хөгжлийн сан"-ийн 2026 оны эхний хагас санхүүгийн үйл ажиллагаанд шалгалт хийж, хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсман эрх зүйн акт, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд үнэлэлт, дүгнэлт өгөх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, мэргэжлийн заавар зөвлөмж өгөх зорилгоор хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ.

1.2. Хяналт шалгалтын бүрэлдэхүүн, хугацаа

Шалгалтыг Санхүүгийн хяналт, шалгалтын улсын ахлах байцаагч Л.Дагийсүрэн ахлан санхүүгийн хяналт, шалгалтын улсын байцаагч А.Дөлгөөн нар 2026 оны 06 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн ажлын 7 хоногт багтаан хийлээ.

1.3. Шалгалтад хамрагдсан асуудлууд

- Монгол Улсын Төсвийн тухай хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Малын тоо толгойн албан татварын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам" болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм журам, зааврын хэрэгжилт
- Сангийн төсвийн төлөвлөлт, санхүүжилт, хөрөнгийн зарцуулалт

4523070018

- Санхүүгийн үйл ажиллагааны үр дүнгийн байдал
- Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, санхүүгийн тайлан
- Сангийн нягтлан бодогч, хяналтын зөвлөл, мэргэжилтнүүдийн хууль тогтоомжид заасан үүрэг, санд төвлөрүүлэх орлогын биелэлт
- Сангийн, санхүү, төсөв, хөрөнгийн үзүүлэлтийн байдал, түүнд нөлөөлсөн хүчин зүйлс
- Харилцах дансны үйл ажиллагааны орлого, зарлагын гүйлгээний нотлох баримт, эрх зүйн үндэслэл
- Дотоодын хяналтын зохион байгуулалт
- Өр авлагын барагдуулалт, үүссэн өр авлагыг данс бүртгэлд бүрэн тусгаж тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байдал
- Санхүүгийн тайланг үнэн зөв гаргаж баталгаажуулсан эсэх
- Өмнөх шалгалтаарх өгсөн үүрэг даалгаврын биелэлтэд хяналт тавин шалгалтыг хийж гүйцэтгэлээ.

Шалгалтад Орхон сумын Орон нутгийн хөгжлийн сангийн Төрийн сангийн 100190352400 тоот дансны гүйлгээ хамрагдлаа.

1.4. Шалгалтад хамрагдсан объектын талаархи товч мэдээлэл

1.4.1 Үндсэн үйл ажиллагааны талаар

Орхон сумын ИТХ-ын 2025 оны 22 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар “Орхон сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2026 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний жагсаалт”-ыг баталсан ба шилжих хөрөнгө хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээний 11 арга хэмжээнд 43,616.3 мянган төгрөг, шинээр эхлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээний 6 арга хэмжээнд 438,145.8 мянган төгрөг, малын тоо толгойн албан татварын төсөл арга хэмжээнд 3 арга хэмжээнд 31,057.4 мянган төгрөг, нийт 512,819.5 мянган төгрөгийг тус тус зарцуулахаар баталжээ.





2026 оны эхний хагас жилийн байдлаар 8 төсөл арга хэмжээнд 207,134.3 мянган төгрөг зарцуулжээ.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг Удирдлагын мэдээллийн санд мэдээлсэн, Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр худалдан авах ажиллагааг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулахаар урилга нийтэлж, үр дүн гарсан байна.

Шилэн дансны нэгдсэн цахим системд 2026 оны эхний хагас жилийн байдлаар 90 мэдээлэл оруулахаас 90 мэдээллийг хугацаанд нь мэдээлж хуулийн хэрэгжилтийг 100 хувь ханган ажиллажээ.

Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааг зохион байгуулах, төсөл боловсруулахдаа Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 9.4 дэх заалт "ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэл болон энэ журмын хэрэгжилтэд төв, орон нутгийн хууль, хяналт, дотоод ба хөндлөнгийн аудитын байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн **ИТХ-ын дэргэдэх хороо** болон иргэд, иргэний нийгмийн байгууллагууд Төрийн аудитын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2015 оны "Дүрэм батлах тухай" 483 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Дотоод аудитын дүрэм" болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжид заасан чиг үүргийн дагуу хяналт тавина" гэснийг мөрдлөг болгон ажилладаг байна.

Орхон сумын ИТХурлын 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 06 дугаар тогтоолоор байгуулагдсан хяналтын хороо нь 2026 онд шинээр эхлэх 6 хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээний 3 ажлын 1 хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн ажлын явцад болон дууссаны дараа хяналт хийж, малын тоо толгойн албан татварын хөрөнгөөр хэрэгжүүлсэн 2 ажилд хяналт хийсэн байна.

1.4.2 Санхүүгийн бариmтыг баталгаажуулсан албан тушаалтан

Шалгалтад хамрагдсан хугацаанд Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүгийн баримтад гарын үсгийн нэгдүгээрийг Орхон сумын Засаг дарга Б.Түмэнцогт, гарын үсгийн хоёрдугаарыг нягтлан бодогч С.Одмандах нар тус тус зурж хөрөнгийг захиран зарцуулжээ.

1.5 Өмнөх шалгалтын талаар

1.5.1 Тус сангийн 2025 оны санхүүгийн тайланд Монгол Улсын Ерөнхий аудиторын "Санхүүгийн тайлангийн аудит хийх байгууллагын жагсаалт, аудит хийх хэлбэр батлах тухай" 2025 оны А/146 дугаар тушаалын дагуу Дархан-Уул аймгийн "Орхон сумын ОНХС"-ийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн хийж 95,862.2 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч, аудитын дүгнэлт гараагүй байна.

1.5.2 Санхүүгийн хяналт, дотоод аудитын газраас 2025 онд тус сумын ОНХСангийн 2023, 2024 оны санхүүгийн баримт, сангийн төлөвлөлт гүйцэтгэл, өр авлагын барагдуулалт, холбогдох хууль болон бусад шийдвэрт нийцүүлэн хяналт шалгалтыг хийж 97,415.0 мянган төгрөгийн хөрөнгийг орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, Сумыг хөгжүүлэх Хөгжлийн цогц бодлого, үндсэн чиглэлд тусгагдаагүй байхад төлөвлөж гүйцэтгэсэн зөрчилд Улсын ахлах байцаагчийн албан шаардлага хүргүүлсэн ба зөрчлийг давтан гаргахгүй гэсэн сумын Засаг даргын 2025.09.19-ний өдрийн 01/250 дугаар албан бичгээр хариуг ирүүлжээ.

Хоёр.Санхүүгийн үйл ажиллагаа, төсвийн хөрөнгийн зарцуулалт

2.1. Орлогын төлөвлөлт гүйцэтгэл

/мян.төгрөг/

№	Орлогын төрөл	2026 он (эхний хагас жил)	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих суурь зардал	438,145.8	145,867.5
2	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	43,616.3	19,417.7
3	Малын татварын орлого	31,057.4	20,924.5
	Нийт дүн	**512,819.5**	**186,209.7**

Орхон сумын ИТХ-ын 2025 оны 12 дугаар сарын 12-ний өдрийн 22 дүгээр "Сумын 2026 оны төсөв батлах тухай" тогтоолоор Орон нутгийн хөгжлийн сангийн 2026 оны орлогыг 512,819.5 мянган төгрөг байхаар баталсан боловч санхүүжилт дутуу олгогдон 186,209.8 мянган төгрөгийн орлогын санхүүжилт авчээ.

2.2 Зардлын төлөвлөлт, гүйцэтгэлийн талаар

/мян.төг/

	Төсөл арга хэмжээний нэр	2026 он (эхний хагас жил)	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Шилжих хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээ	**43,616.3**	-
1	Орхон ЭМТ-ийн гадна фасад, дээврийг засаж шинэчлэх	10,617.7	-

2	Төв гудамжны засвар, гадна тохижилт, замын засвар /Чанарын баталгаа/	5,505.6	-
3	Дизель түлшээр ажилладаг цахилгаан үүсгүүр /генератор/ худалдан авах /Чанарын баталгаа/	1,388.6	-
4	Энхтал багт хадлангийн талбай хашаажуулах /Чанарын баталгаа/	2,500.0	-
5	Энхтал багт хогний машин худалдан авах /Чанарын баталгаа/	1,497.0	-
6	Сумд экскаватор худалдан авах /Чанарын баталгаа/	8,800.0	-
7	Өөрөө буулгагч тээврийн хэрэгсэл худалдан авах /Чанарын баталгаа/	8,497.5	-
8	Орхон ЭМТ-ийн гадна фасад, дээврийг засаж шинэчлэх /Чанарын баталгаа/	4,809.9	-
9	Орхон ЭМТ-ийн гадна фасад, дээврийг засаж шинэчлэх /Чанарын баталгаа/	-	-
10	79-ийн тариалангийн талбай руу цахилгаан татах /Чанарын баталгаа/	-	-
11	Хорооллын камержуулалт гэрэлтүүлэг, /Чанарын баталгаа/	-	-
	Шинээр эхлэх хөрөнгө оруулалт	**438,145.8**	**183,847.5**
1	Хот байгуулалтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө	88,620.00	37,980.00
2	Энхтал багийн 96-р зөрлөг хэсэгт хүүхдийн тоглоомын талбай, 3х3 сагсан бөмбөгийн талбайн бараа материал худалдан авах	20,000.00	-
3	9-р цэцэрлэгийн гадна фасадыг шинэчлэх	268,220.8	112,408.77
4	Сургуулийн ухаалаг анги (дэлгэц, самбар) худалдан авах	20,000.0	19,900.00
5	Улсын баяр наадам	15,000.00	-
6	2027 онд ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр, арга хэмжээний зураг төсөв ТЭЗҮ боловсруулах ажлын төлбөр	26,305.00	6,750.00
	Малын тоо толгой албан татвар	**31.057.40**	**16.726.00**
1	Мод бут тарих	10,000.0	9,999.00
2	Мод бут хамгаалалтын хашаа барих	10,000.0	-
3	Гамшгаас хамгаалах	11,057.4	6,727.00

2026 оны эхний хагас жилийн байдлаар нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 1, шууд худалдан авалтын аргаар 8 арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулж, сангийн хөрөнгөөс барилга байгууламжийн 2 төсөл арга хэмжээнд 112,408.8 мянган төгрөг, тоног төхөөрөмж худалдан авах 2 төсөл

арга хэмжээнд 19,900.0 мянган төгрөг, зөвлөх үйлчилгээ 13,558.8 мянган төгрөг, өмнөх оны үлдэгдэл 19,417.7 мянган төгрөг, малын тоо толгойн албан татвараар хэрэгжих төсөл арга хэмжээнд 20,924.5 мянган төгрөг, нийт 207,134.3 мянган төгрөгийн санхүүжилтийг олгон зарцуулжээ.

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлэгтэй холбоотойгоор сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний санхүүжилт хүлээгдэж байна.

Гурав.Санхүү, бүртгэлийн ололттой тал, шалгалтаар илэрсэн зөрчил дутагдал, зөрчигдсөн хууль, тогтоомж, дүрэм, журам, стандартын хэрэгжилт

3.1. ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлт

Орхон сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 22 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт "Орхон сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2026 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний жагсаалт"-д

1. "Орхон Эрүүл мэндийн төвийн гадна фасад, дээврийг засаж шинэчлэх",

8.Орхон Эрүүл мэндийн төвийн гадна фасад, дээврийг засаж шинэчлэх/чанарын баталгаа/

9.Орхон Эрүүл мэндийн төвийн гадна фасад, дээврийг засаж шинэчлэх/чанарын баталгаа/ гэсэн 3 арга хэмжээ тусган төсөвт өртөг, санхүүжих дүнг зэргийг тусган баталжээ.

Гэрээлэгч тал бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхдээ гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь, чанартай биелүүлэх баталгаа болгон захиалагч талд өгдөг чанарын баталгааг хөрөнгө оруулалтын жагсаалтад тусгасан нь шинэ хөрөнгө оруулалт мэт, төсөвт өртгийг нэмэгдүүлж буй нь төсвийн төлөвлөлтийг буруу төлөвлөсөн байна.

Үүнээс үүдэн Орхон сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 22 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт "Орхон сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2026 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний жагсаалт"-аар 20 хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг батлагдаж, удирдлагын мэдээллийн системд 18 хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээгээр мэдээлэгджээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2.төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 3.4.1 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтыг хууль, журмын дагуу боловсруулан бэлтгэж тухайн шатны

ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулах, 6 дугаар зүйлийн 6.8.Сум, дүүргийн ИТХ нь сум, дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтыг хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ тус бүрээр хэлэлцэн энэхүү журмын 8 дугаар хавсралтад заасан маягтын дагуу батална.гэсэнтэй нийцэхгүй байна.

Цаашид ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтыг давхардуулахгүйгээр боловсруулж ИТХ-д өргөн мэдүүлэхийг Орхон сумын Засаг дарга, нягтлан бодогч, ажилтан нарт анхааруулаа.

3.2 Иргэдээс авах санал

Аймаг, сумдын төсвийн ерөнхийлөн захирагч нар ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэхэд иргэд, олон нийтийн оролцоог хангах талаар Төсвийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.14-д заасны дагуу санал асуулгыг цахим, бүлгийн ярилцлага, саналын хуудас зэргээр авч, эрэмбэлжээ.

Орхон сумын санал өгсөн иргэдийн тоог хөдөлмөрийн насны иргэдийн тоотой харьцуулахад 2025 онд 22.6 хувьтай байгаа нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө иргэдийн саналыг хүртээмжтэй байдлаар авахгүй байна.

Малын тоо толгойн албан татварын хөрөнгөөр хийгдсэн 10,000.0 мянган төгрөгийн төсөвтэй мод бут тарих, 10,000.0 мянган төгрөгийн төсөвтэй мод бут хамгаалах хашаа барих төсөл арга хэмжээнүүд иргэдээс авсан саналд тусгагдаагүй байхад төсөвт тусган батлуулж хэрэгжүүлсэн байна. Уг асуудлыг тодруулахад Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд төлөвлөж батлуусан гэсэн тайлбарыг ОНХСан хариуцсан мэргэжилтэн өглөө.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.6-д "Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ", 63 дугаар зүйлийн 63.1-д "Баг, хорооны Засаг дарга Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар баг, хороодод олон нийтийн нээлттэй санал асуулга явуулна.", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д "Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр зөвхөн орон нутгийн иргэдийн санал авсан, хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, хуульд заасан

холбогдох зөвшөөрөл олгогдсон хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ.", Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.3.2.ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх 6 дугаар зүйлийн 6.4 "Ажлын хэсэг нь баг, хороодоос ирсэн саналыг нэгтгэж эрэмбэлэхдээ дараах үзүүлэлтүүдийг харгалзан зөвлөмж, дүгнэлт гарган сум, дүүргийн Засаг даргад хүргүүлнэ", 6.4.1 "Баг, хороодоос ирүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь баг, хорооны иргэдийн олонхын саналаар дэмжигдсэн эсэх" гэсэнтэй тус тус нийцэхгүй байна.

Иймд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээг Төсвийн тухай хууль болон холбогдох журамд заасан шаардлага, нөхцөлд нийцүүлэн баталж байх шаардлагатай байна.

Иргэдээс санал аваагүй төсөл арга хэмжээг батлан хэрэгжүүлснийг давтан гаргасан тул холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох саналыг удирдах албан тушаалтанд гарган Улсын ахлах байцаагчийн албан шаардлага хүргүүлэв.

3.3 ОНХСангийн санхүүжилтийн талаар

ДУАОСЗДТГ/20260101015 дугаартай 264,695.8 мянган төгрөгийн төсөвтэй "9-р цэцэрлэгийн фасад засварын ажил"-ын гэрээний тусгай нөхцөлийн ГЕН 5.5 дахь заалт "Урьдчилгаа төлбөр олгох хугацаа: 2026.03.05", ГЕН 5.6 дахь заалтад "Төлбөр төлөх хугацаа: ажлын гүйцэтгэлээр 3 хувааж олгох, урьдчилгаа 30%, гүйцэтгэл 70%-д хүрсэн үед дундын санхүүжилт 40%, ажлыг дуусган актаар хүлээлгэж өгсөн өдрөөс хойш ажлын 7 хоногт багтаан үлдэгдэл 30%-ийн санхүүжилтийг олгох" гэсэн байна.

Гэтэл урьдчилгаа төлбөр 30% болох 79,408.7 мянган төгрөгийг 2026.02.28-ны өдрөөс 2026.03.23-ны өдөр хүртэл 4 удаагийн ажил гүйлгээгээр хувааж олгосон байна.

2026.08.01.

Тус ажлыг гүйцэтгэж дууссан, актаар хүлээлгэж өгсөн байхад нийт 112,408.7 мянган төгрөгийн санхүүжилт олгоод үлдэгдлийг барагдуулаагүй нь захиалагч тал үүргээ биелээгүй ба 41.7 мянган төгрөгийн гүйцэтгээгүй үүргийн алдангийг гүйцэтгэгчид 2026.06.30-ны өдрийн байдлаар олгохоор байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйл "Захиалагчийн эрх, үүрэг", 48.2.11 дахь заалт "Гэрээнд заасан нөхцөлийн дагуу төлбөр тооцоог гүйцэтгэх", ДУАОСЗДТГ/20260101015 дугаартай "9-р цэцэрлэгийн фасад засварын ажил"-ын гэрээний тусгай нөхцөлийн ГЕН 5.5 дахь заалт ".... ажлыг дуусган актаар хүлээлгэж

өгсөн өдрөөс хойш ажлын 7 хоногт багтаан үлдэгдэл 30%-ийн санхүүжилтийг олгох" гэсэнтэй нийцэхгүй байна.

Дээрх байдлыг ОНХСан хариуцсан мэргэжилтэнээс тодруулахад аймгийн ОНХСангаас олгох орлогын шилжүүлэгтэй холбоотой гэж тайлбарласан ба гүйцэтгэгч байгууллагад санхүүжилтийг бүрэн олгоход анхаарч, аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-т уламжлах талаар сумын Засаг дарга, нягтлан бодогч нарт зөвлөлөө.

3.4 Хийгдсэн ажлын гүйцэтгэлийн талаар

Захиалагч Орхон сумын Засаг дарга Б.Түмэнцогт, гүйцэтгэгч "Орхон Баян Бонн" ХХК-ийн захирал Б.Нямдаваа нарын хооронд хийсэн "Сургуулийн ухаалаг анги (дэлгэц, самбар) худалдан авах" 19,900.0 мянган төгрөгийн гэрээний үнэтэй 5 ширхэг ухаалаг самбар, 5 ширхэг энгийн самбар худалдан авах ДУАОСЗДТГ/20260602016 дугаар гэрээний техникийн тодорхойлолтод **windows system i7 6-р үе**, **Android-11, 8GB-Ram, 128GB-Hard** гэсэн үзүүлэлтийг тусгасан байх ба байгууллагын цахим хуудсаар (фэйсбүүк) нийтэд мэдээлэхдээ техникийн толорхойлолтыг "...**windows system i7 4-8-р үе...**", үзүүлэлтэйгээр нийтэлж зарлажээ.

Гэрээний хэрэгжилтийг нягтлан шалгах хүрээнд нийлүүлэгдсэн ухлаалаг самбарын чанар, техникийн тодорхойлолтод тусгагдсан үзүүлэлтийг газар дээр нь очиж танилцахад техникийн үзүүлэлт тодорхойлолтод заасан үзүүлэлтийг хангаагүй байна.

Тус компанийн нийлүүлсэн ухаалаг самбарын үзүүлэлтийг шалгахад **windows system i7 3-р үе, Android-13, 8GB-RAM, 256GB-HARD**-ын хүчин чадалтай байна. Самбарыг хүлээн авсан ажлын хэсэг болон ОНХСан хариуцсан мэргэжилтэнээс **windows system**-ийн талаар тодруулахад 3,6 дугаар үед ялгаа байхгүй, рам болон хардын үзүүлэлт өндөр байсан тул хүлээн авсан гэсэн тайлбар өглөө.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх заалтад "Захиалагч, шалгарсан оролцогчийн хооронд байгуулах бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний гол нөхцөл нь тендер шалгаруулалтын баримт бичиг болон шалгарсан оролцогчийн ирүүлсэн тендер байна", 2026 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр байгуулсан "Сургуулийн ухаалаг анги (дэлгэц, самбар) худалдан авах" ДУАОСЗДТГ/20260602016 дугаар гэрээний техникийн тодорхойлолтын **windows system i7 6-р үе**, 3.1 дэх заалтад "гүйцэтгэгч нь ажлыг **техникийн тодорхойлолтод заасан шаардлагад нийцүүлэн** гэрээнд заасан хугацаанд захиалагчид хүлээлгэн өгнө" гэсэнтэй тус тус нийцэхгүй байна.

Цаашид шууд худалдан авалтын нийтэд мэдээлэх зарлалын техникийн тодорхойлолт, гэрээний техникийн тодорхойлолтыг ижил үзүүлэлтээр тусгах, барааг хүлээн авахдаа техникийн тодорхойлолттой нийцсэн эсэхэд хяналт тавьж байхыг холбогдох албан хаагчдад зөвлөллөө.

Дөрөв.Авсан арга хэмжээ, дүгнэлт, санал

4.1 Авсан арга хэмжээ

4.1.1 Шалгалтаар илэрсэн дээрх зөрчилт үйлдлүүд нь сангийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах нөхцөл болох тул холбогдох хууль тогтоомжуудын хэрэгжилт, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журмыг ханган ажиллах шаардлагатай байгааг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг захиран зарцуулах эрх бүхий сумын Засаг дарга, мэргэжилтэн, нягтлан бодогч нарт танилцуулж мэргэжлийн зөвлөгөө, зөвлөмж өгч шалгалтаар илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй ажиллахыг анхааруулаа.

4.1.2 Шалгалтын явцад нягтлан бодогч, төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтэнтэй уулзаж асуулга, тодруулга авч Захиргааны ерөнхий хуулийн дагуу сонсох ажиллагааны болон захиргааны шийдвэрийг мэдэгдэх хуудас зэргийг хөтөлсөн болно.

4.1.3 Шалгалтын тэмдэглэлд тусгагдсан үүрэг даалгаврын биелэлтийг ханган ажиллах, зөрчлийг арилгасан тухайгаа 2026 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн дотор Санхүүгийн хяналт, дотоод аудитын газарт албан бичгээр мэдэгдэхийг Орхон сумын Засаг дарга, мэргэжилтэн, нягтлан бодогч нарт хариуцуулав.

4.2 Дүгнэлт, цаашид авах арга хэмжээний тухай санал

4.2.1 Дүгнэлт

Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ыг хэрэгжүүлэхдээ иргэдийн саналыг хүртээмжгүй байдлаар аваагүй, саналд тусгагдаагүй төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх зөрчил давтагдан гарсан байна.

4.2.2 Цаашид авах арга хэмжээний тухай санал

1. Орон нутгийн хөгжлийнсангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг давхардуулахгүйгээр төлөвлөж батлуулах

2. ОНХСангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний саналыг иргэдээс хүртээмжтэй байдлаар авах, санал авсан төсөл арга хэмжээг жагсаалтад оруулж батлуулах

3. Гүйцэтгэгч байгууллагын нийлүүлж буй бараа материалын чанар, техникийн тодорхойлолтод тавих хяналтыг сайжруулах;

ТЭМДЭГЛЭЛ

БИЧСЭН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ Л.ДАГИЙСҮРЭН

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ А.ДӨЛГӨӨН

ТАНИЛЦСАН:

ОРХОН СУМЫН ЗАСАГ ДАРГА Б.ТҮМЭНЦОГТ

НЯГТЛАН БОДОГЧ С.ОДМАНДАХ

ЭДИЙН ЗАСАГЧ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН АЖИЛТАН Д.МИШЭЭЛТ

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 07 сарын 09 өдөр Дугаар 23-06-26/37 Дархан

ЗӨРЧИЛ АРИЛГУУЛАХ ТУХАЙ

Дархан-Уул аймгийн Засаг даргын баталсан Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын 2026 онд хийх хяналт шалгалтын төлөвлөгөө, , 2026 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 23-06-26-01/06 дугаар удирдамжийн дагуу Орхон сумын "Орон нутгийн хөгжлийн сан"-ийн 2026 оны эхний хагас санхүүгийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт санхүүгийн хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ.

Санхүүгийн хяналт шалгалтаар Малын тоо толгойн албан татварын хөрөнгөөр хийгдсэн 10,000.0 мянган төгрөгийн төсөвтэй мод бут тарих 10,000.0 мянган төгрөгийн төсөвтэй мод бут хамгаалах хашаа барих төсөл арга иргэдийн санал аваагүй байхад төлөвлөж гүйцэтгэсэн, зөрчил илэрлээ.

Мөн тус газраас 2023, 2024 оны орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар иргэдийн санал аваагүй төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэнд санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагчийн албан шаардлага өгсөн бөгөөд зөрчил давтагдсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.6-д "Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ", 63 дугаар зүйлийн 63.1-д "Баг, хорооны Засаг дарга Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар баг, хороодод олон нийтийн нээлттэй санал асуулга явуулна.", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д "Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр зөвхөн орон нутгийн иргэдийн санал авсан, хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, хуульд заасан холбогдох зөвшөөрөл олгогдсон хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ.", Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.3.2.ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх 6 дугаар зүйлийн 6.4 "Ажлын хэсэг нь баг, хороодоос ирсэн саналыг нэгтгэж эрэмбэлэхдээ дараах үзүүлэлтүүдийг харгалзан зөвлөмж, дүгнэлт гарган сум, дүүргийн

Засаг даргад хүргүүлнэ", 6.4.1 "Баг, хороодоос ирүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь баг, хорооны иргэдийн олонхын саналаар дэмжигдсэн эсэх" гэсэнтэй тус тус нийцэхгүй байна.

Иймд Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1, 69.4, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9.8, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан "Дотоод аудитын дүрэм"-ийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 7 дугаар зүйлийн 7.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар **ШААРДАХ нь**:

1. Хууль журмын дагуу иргэдийн санал аваагүй төсөл арга хэмжээг боловсруулсан ажлын хэсгийн гишүүдэд хариуцлага тооцох, зөрчлийг давтан гаргахгүй байх

2. Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь заалтын дагуу албан шаардлагаар өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлж холбогдох арга хэмжээ авч биелэлтийг 2026 оны 08 дугаар сарын 30-ны дотор Санхүүгийн хяналт, дотоод газарт албанд албан бичгээр ирүүлэх.

Эс зөвшөөрвөл Захиргааны ерөнхий хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх заалтад "Хуульд өөрөөр заагаагүй бол иргэн, хуулийн этгээдээс түүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн гэж үзвэл холбогдох захиргааны актыг хууль болон зорилгодоо нийцэж байгаа эсэх талаар хянуулахаар гомдол гаргах эрхтэй" болохыг дурдсугай.

АЛБАН ШААРДЛАГА БИЧСЭН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ Л.ДАГИЙСҮРЭН

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ А.ДӨЛГӨӨН

ТАНИЛЦАЖ ХҮЛЭЭН АВСАН:

ОРХОН СУМЫН ЗАСАГ ДАРГА Б.ТҮМЭНЦОГТ

НЯГТЛАН БОДОГЧ С.ОДМАНДАХ

ЭДИЙН ЗАСАГЧ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО
ТӨЛӨВЛӨЛТИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН
АЖИЛТАН Д.МИШЭЭЛТ